



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 99

Номгон

**Үндсэн хөрөнгө акталж данснаас
хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Баянговь сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэрийн 90 669 726.76 төгрөгийн өртөг бүхий хавсралтад заагдсан хөрөнгийг акталж данснаас хассугай.

2. Баянговь сумын Засаг дарга /Б.Эрдэнэбилэг/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

2.1. Тус сумын актлагдсан эмнэлэгийн барилгын газрыг чөлөөлж, холбогдох хууль журмын дагуу мооргийн барилгыг бариулах;

2.2 Актлагдсан Өрхт 2 дугаар багийн төвийн барилгын доорхи 1000м² талбай бүхий газрыг 2,0 сая төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгасан тул газрын тухай хуулийн дагуу газрын асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай саналаа боловсруулж 2019 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2019 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

1190163

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

(Handwritten signature and scribbles over the stamp)

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 24-ний
өдрийн 99 дүгээр тогтоолын хавсралт

АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгуу ллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашигла л тад нон орсон	Тоо ширхэг	Нэр бүрийн үнэ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Тайлбар	
1	Баянговь сум	ЗДТГ	2-р багийн хуучин барилга	18.12.31	1,00	3208827,69	3208827,69	343802,97	2865024,72	Уг барилга 1967 онд баригдсан чулуун барилга ашиглах боломжгүй. Шал нь шар шавар, дээврийн дам нуруу мод 2010 онд доошоо цөмөрч унаад ашиглахаа больсон. Дээврийн зүүн талын хэсгийн төмөр, мод салхинд хийссэн. Бүх цонхыг дээврийн төмрөөр төмөрлөсөн. Шинэ багийн төв хуучин багийн төвөөс 3км-ийн зайтай тал дээр барисан. 2018 онд дахин үнэлгээ хийсэн. 1000м2 талбай бүхий газрыг 2018 онд үнэлж 2,0 сая төгрөгөөр бүртгэлд тусгасан. Барилгыг ахталж газар чөлөөлөх	
2	Баянговь сум	ЗДТГ	Жижиг трактор	07.01.01	1,00	2620640,00	2620640,00	2620640,00	0,00	2007 онд ХХААГамнаас газар тариалангийн зориулалтаар ирсэн. Иргэн Пүрэвзэ гэрээгээр ашиглах байгаад 2012 онд буцааж хүлээлтэн өгсөн. 2013-2014 онуудад ашиглаж байсан бөгөөд мотор цохиод сэлбэг олдохгүй зогссон.	
3	Баянговь сум	ЭМТ	Эмнэлтийн барилга	18.12.31	1,00	83490259,07	83490259,07	2504707,74	80985551,33	1960 онд ашиглалтад орсон чулуун барилга 2003 онд шинэ барилга ашиглалтад ороод ашиглаагүй. Одоогоор 2 өрөөг мооргоор ашиглаж байгаа боловч стандартын шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинэ моорог барихаар санал орсон. ЦЭСДА ХХК зураг төсвийг хийсэн. Уг барилгыг ахталж газар чөлөөлж дээр шинэ мооргийн барилга барих. 2018 онд дахин үнэлэгдсэн. Мөн 1399м2 талбай бүхий газрыг 2798000 төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгасан.	
4	Гурванбулаг сум	ЗДТГ	Хүлэмж	10.01.01	1,00	1350000,00	1350000,00	843750,00	506250,00	Гурванбулаг ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хүлэмж 2010 онд ашиглалтад орсон Төмөр карказ, гялгар хучилттай, 144 м2 бүхий талбайтай одоогоор гялгар хучилт урагдаж дахин ашиглах боломжгүй болсон. Ашиглалтад орсноос хойш засвар үйлчилгээ хийгдэж байгаагүй. Одоогоор ашигладаггүй Гурванбулаг сумын төвөөс баруун хойш 8 км-т Хар усан голын эрэгт байрлалтай	
							90669726,76	6312900,71	84356826,05		
ДҮН											